

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2024.11.29

Нэг.Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт

А. Төрийн албаны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэрээр:

1. Засгийн Газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолыг үндэслэн төрийн захиргааны 34, төрийн үйлчилгээний 5 албан хаагчийн цалинг шинэчлэн тогтоолоо.

2. Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.1 дахь заалтыг үндэслэн төрийн захиргааны албан тушаалд тасралтгүй 5 ба түүнээс дээш жил ажилласан 23 албан хаагчид 139,312,600 төгрөгийн тэтгэмж, урамшуулал олголоо.

3. 3 хүртэлх насны хүүхэдтэй 4 албан хаагчид хүүхэд асрах чөлөө, 2 албан хаагчид жирэмсэн амаржсаны амралт олгов.

4. Шинээр томилогдон Газрын мэдээллийн сангийн сургалтанд хамрагдан сертификат авсан 2 албан хаагчид ГХБХБГ-ын даргын тушаалаар Газрын кадастрын нэгдсэн ситем, Газрын биржийн цахим системд хандах эрх олголоо.

5. Байгууллагын Баримт нягтлан шалгах комисс, ёс зүйн зөвлөлийг хамт олны хурлаар хэлэлцэн баталж байгууллагын даргын тушаалаар шинээр байгууллаа.

Б.Төрийн албаны зөвлөлийн зөвлөмжийн хэрэгжилтийн талаар:

Зохион байгуулалтын зарим арга хэмжээний тухай 2020.03.12 Дугаар 01

Нэг. Сумдын Газрын даамлуудад 3 удаа уулзалт зөвлөгөөн зохион байгууллаа. Давхардсан тоогоор 123 албан хаагч 23 төрлийн цахим болон танхимийн сургалтад хамрагдлаа. Энэ онд албан хаагчдын сургалтад 10819,0 төгрөгийг зарцуулсан байна. “Хариуцлагатай газрын харилцаа” аяны төлөвлөгөөнд тусгагдсан судалгааг мэргэжилтэн, 19 сумын даамлуудаас бүрэн гаргаж илэрсэн зөрчлийг бүрэн арилгах чиглэлээр нийт 610 иргэн, хуулийн этгээдийг гэрээг дүгнэж, газрын төлбөрөө хугацаанд нь төлөөгүй 159 иргэн, хуулийн этгээдэд, 2 жил дарааллан ашиглаагүй 79 иргэн хуулийн этгээд, газрын талбайн хэмжээг өөрчилсөн 93 иргэн, хуулийн этгээд хугацаатай албан мэдэгдэл хүргүүлж 13 хашаа, 2 төмөр хаалтыг буцаан татуулсан.

Сумдын даамлууд газрын кадастрын мэдээллийн системийн чиглэлээр бэлдсэн брошур байршуулах түгээх /egazar.gov.mn/ ажлыг нээлттэй хаалга өдөрлөг, багийн

хурлууд дээр 21 чиглэрээр хийж нийт 1740 иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл өгсөн, цахимаар 223 төрлийн зөвлөмж, постер, контент, реел бэлтгэн 22868 хандалтыг авсан байна, 152 төрлийн хэвлэмэл хуудас хэвлэж 2405 иргэнд тарааж мэдээллэсэн.

Хайрхандулаан сум нь “Мэдээлэл” сонинд нийтлүүлэн 1000 гаруй өрхөд хүргэсэн. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2 ярилцлага өгч 21350 хүний хандалттай, нийт 43 сургалт явуулж 2364 иргэн, хуулийн этгэд хамрагдаж 89 төрлийн мэдээлэл бэлтгэн 8907 хүнд хүргэсэн.

Газар өмчлөл, газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системийн танилцуулга, “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам”-ыг мэдээлэх, таниулаар нийт 723 хэвлэмэл хуудас тарааж 104 контент, зөвлөмж, постерийг хүргэж ажилласан.

Хоёр. Төрийн албаны нөөцөд бүртгэлтэй тусгай шалгалт өгсөн иргэн байхгүй улмаас 4 сумын газрын даамлын сул орон тоог 4 мэргэжилтэн ажлыг хавсран гүйцэтгэж байна.

Бат-Өлзий сумын Газрын даамлын сул орон тоонд тусгай шалгалт өгч тэнцсэн иргэнийг Төрийн албаны салбар зөвлөлийн Нэр дэвшүүлсэн тогтоолыг үндэслэн 2024.11.01-ний өдрөөс томилон ажиллуулж байна.

Барилгын техникийн хяналт гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай цахилгааны инженер, барилгын инженерүүд, жолоочийг захиалагчийн хяналтын зардлаас цалинжуулан Хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулж байна.

Гурав. Албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулах зорилгоор байгаа нөөц боломжоо ашиглан сургалтын өрөөг 3 албан хаагч суух боломжоор ханган тохижууллаа. Барилгын материалын лабораторийн барилга бариулах саналыг 2025 оны улсын төсвийн төсөлд санал хүргүүлсэн. 2025 онд зураг төсөв хийлгэх санхүүжилтийг шийдвэрлүүлсэн.

2023 онд улсын төсөв болон хувийн хэвшлийн 42 барилга ашиглалтанд орсон. Мөн засварын ажил 32 байгууллага хийж гүйцэтгэсэн. Барилгын материалын лаборатори нь 15 төрлийн материалд 112 төрлийн сорилт, шинжилгээг хийж барилгын чанарт хяналт хийж байна. Цаашид барилга байгууламжийн чанар аюулгүй байдлыг хангахын тулд шинжилгээний нэр төрлийг олшруулж орон нутагт хийх шаардлагатай байна. Энэ талаар барилга угсралтын компаниудаас удаа дараа

санал ирүүлж байна. Мэргэжлийн хяналтын газар татан буугдаж улсын 2 байцаагч манай газарт шилжин ирсэн. Мөн барилгын болон цахилгаан холбоо дохиоллын инженерүүдийн гэрээгээр авч ажиллуулж байгаатай холбоотойгоор ажлын өрөө, тасалгааны хэрэгцээ шаардлага нэмэгдсэн. Нэг өрөөнд 8-9 мэргэжилтэн хувиарлагдаж ажлын байрны эрүүл ахуй алдагдаж ажил үүргээ гүйцэтгэхэд хүндрэлтэй байна.

Барилгын техникийн хяналтаар байнга хөдөө сумдад ажилладаг 14 албан хаагчид зайлшгүй шаардлагын дагуу хувцас, хамгаалах хэрэгсэл авахад 2,870,000 төгрөгийг зарцууллаа.

МУ-ын Ерөнхийлагчийн зарлигаар улсын хэмжээнд 2003-2023 оны хооронд олгосон газарт хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу манай аймгийн 2 суманд хийгдсэн хяналт шалгалтын ажилд шаардагдах хэрэглэгдэхүүнд 2771500 төгрөгийг зарцууллаа.

Албан хаагчдад өвлийн улиралд ханиад томуу, эрүүл мэндэд эрсдэл үүсэхээс сэргийлж биеийн дархлаа дэмжих зорилгоор 190,000 төгрөгийн шар тос, аарц худалдан авч буцалган өгч байна.

Байгууллагын ариун цэвэр, албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг бүрдүүлж гар угаах хэрэгсэл, алчуур, цаас авахад зориулж 802,650 төгрөг зарцуулсан байна.

Төрийн албанд ёс зүй, сахилга, хариуцлагыг сайжруулах тухай
2020.06.18 Дугаар 02

Байгууллагын ёс зүйн зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан.

Албан хаагчдыг Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 сургалтад хамруулж Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга, хариуцлагатай холбоотой 3 чиглэлийн сургалтад оролцуулсан.

Төрийн үйлчилгээг иргэдэд тэгш хүртээмжтэй хүргэх, байгууллагын эд хөрөнгө техник хэрэгслийг хувийн зорилгоор ашиглахгүй байх талаар албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд тусган хэрэгжилтийг дүгнэн ажиллаж байна.

Байгууллагын болон адбаны нууцыг хадгалах, задруулахгүй байх талаар нууцтай холбогдох албан хаагчид байгууллагын нууцын асуудал хариуцсан ажилтантай гэрээ байгуулан хэрэгжилтийг ханган биелүүлж байна.

Төрийн албан хаагчдын манлайлал, ур чадвар, ёс зүйг дээшлүүлэх зорилгоор Соёлын газартай хамтран “Өв эрдэнийн Өвөрхангай” лекцид сумдын газрын даамлуудаа оролцуулан нийт албан хаагчидаа хамрууллаа.

Ажлын цагийн бүтээмжийг нэмэгдүүлэх, ажлын байранд албан хувцаслах, албан бус үг хэллэг хэрэглэхгүй байх, хамт олны уур амьсгалыг бүрдүүлэх талаар байгууллагын хурал, зөвлөгөөн байнга сануулдаг.

2024 онд ёс зүйн сахилга хариуцлагын талаар өргөдөл гомдол ирээгүй.

Төрийн албаны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх тухай 2020.10.28 Дугаар 03

Төрийн албан хаагчдыг хууль бус томилгоогоор өөрчлөх тохиолдол гараагүй.

Сургалтын бодлогыг хэрэгжүүлэх тухай 2020.11.05 Дугаар 04

Төрийн албаны мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 1 албан хаагч хамрагдаж байна.

Хоёр. Төрийн албан хаагчийн ёсзүйн хэм хэмжээний хэрэгжилт, ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны талаар:

Байгууллагын ёс зүйн зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан.

Албан хаагчдыг Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 сургалтад хамруулж Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга, хариуцлагатай холбоотой 3 чиглэлийн сургалтад оролцуулсан.

Төрийн үйлчилгээг иргэдэд тэгш хүртээмжтэй хүргэх, байгууллагын эд хөрөнгө техник хэрэгслийг хувийн зорилгоор ашиглахгүй байх талаар албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд тусган хэрэгжилтийг дүгнэн ажиллаж байна.

Байгууллагын болон адбаны нууцыг хадгалах, задруулахгүй байх талаар нууцтай холбогдох албан хаагчид байгууллагын нууцын асуудал хариуцсан ажилтантай гэрээ байгуулан хэрэгжилтийг ханган биелүүлж байна.

Төрийн албан хаагчдын манлайлал, ур чадвар, ёс зүйг дээшлүүлэх зорилгоор Соёлын газартай хамтран “Өв эрдэнийн Өвөрхангай” лекцид сумдын газрын даамлуудаа оролцуулан нийт албан хаагчидаа хамрууллаа.

Ажлын цагийн бүтээмжийг нэмэгдүүлэх, ажлын байранд албан хувцаслах, албан бус үг хэллэг хэрэглэхгүй байх, хамт олны уур амьсгалыг бүрдүүлэх талаар байгууллагын хурал, зөвлөгөөн байнга сануулдаг.

2024 онд ёс зүйн сахилга хариуцлагын талаар өргөдөл гомдол ирээгүй.

Гурав. Төрийн албан хаагчийн сургалт нийгмийн баталгааг хангах хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар:

1. Байгууллагын албан хаагчдыг мэргэжлийн чиглэлийн чадавхжуулах сургалт болон байгууллагын дотоод сургалтад хамрагдахад байгууллагаас 10,819,000 төгрөгийг томилолт, хоол, унааны зардалд зарцуулсан байна.

2. 1 албан хаагчид магистрийн сургалтад хамрагдахад нь ажлын цагийг зохицуулах дэмжлэг үзүүлж дипломоо гардан авахад байгууллагын дотоод журамд заасны дагуу 100000 төгрөгийн тусламж үзүүлэв.

3. Төрийн захиргааны 15 албан хаагчид аймгийн Засаг даргын 2024 оны “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох тухай” Б/05 дугаар захирамжаар 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн сар бүр 18-24 хувийн нэмэгдэл олгов.

4. Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журмын дагуу хүний нөөцийн удирдлагын нэгдсэн системд албан хаагчдын ажилласан хугацааг тооцон олгож байна.

5. Сар шинийн баяр, Ахмадын баярыг тохиолдуулан байгууллагын 5 ахмад настанд 500,000 (таван зуун мянга) төгрөгийн бэлэг дурсгалын зүйл өгөв.

6. Албан хаагчдад өвлийн улиралд ханиад томуу, эрүүл мэндэд эрсдэл үүсэхээс сэргийлж биеийн дархлаа дэмжих зорилгоор 190000 төгрөгийн шар тос, аарц худалдан авч буцалган өгч байна.

7. 4 албан хаагчийн ар гэрт шинээр мэндэлсэн хүүхдүүдэд нь зориулж 400,000 (хоёр зуун мянга) төгрөгийн тэтгэмж олгов.

8. 1 албан хаагч өөр ажилд шилжин ажиллах, 1 албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарах болсон тул байгууллагын албан хаагчдын зүгээс 1,000,000 (нэг сая) төгрөгийн дурсгалын зүйл өгөв.

9. 5 албан хаагчийн ар гэрт гачигдал тул тус бүр 300,000 (гурван зуун мянга) төгрөгийн буцалтгүй тусламж үзүүллээ.

10. 1 албан хаагч хүүхдийнхээ сэвлэгийг үргээхэд нь зориулж 200,000 (хоёр зуун мянга) төгрөгийн тэтгэмж олголоо.

11. Сул орон тоо болон жирэмсэн амаржсаны амралттай хүний тооноос харгалзан байгууллагын цалингийн сангийн хэмнэлтээс 38 албан хаагчийн өдрийн хоолны хөнгөлөлтийг 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс өдрийн 20,000 (хорин мянга) төгрөгийг олгож байна.

12. Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэн 45 албан хаагчид 1,3 дугаар улирал, хагас жилээр нийт 57,850,271 төгрөгийн урамшуулал олгосон байна.

Дөрөв. Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөлт, бүрдүүлэлтийн талаар ТАЗ-ийн 2019 оны 05 дугаар тогтоолын дагуу 42 албан хаагчийн хувийн хэргийг бүрдүүлэн баяжуулалтийг тухай бүр хийж байна. Энэ онд шинээр 2 албан хаагчийн хувийн хэргийг бүрдүүлсэн.

Тав. Төрийн албан хаагчийн тоо бүртгэл хөтлөлт, хүний нөөцийн системд бүртгэгдсэн албан хаагчдын мэдээллийг шинэчлэх, баяжилт нууцлалыг хангасан талаар.

Хүний нөөцийн системд нийт 44 албан хаагчийн бүртгэл байна. Хүүхэд асрах чөлөөтэй 4, жирэмсэн амаржсаны амралттай 1, одоо ажиллаж байгаа 39 албан хаагчийн мэдээлэл бүртгэгдсэн байна. 6 албан хаагчийг шинээр бүртгэж 2 албан хаагчийг өөр ажилд шилжүүлж 1 албан хаагчийг тэтгэвэрт гарсан тул бүртгэлээс хасав.

Зургаа. Байгууллага, нэгжийн болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, ажлын үр дүнг үнэлж дүгнэх үйл ажиллагааны талаар

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг барилгын хөгжлийн төв, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газар, Аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжүүлж ажиллаж байна. 2 хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгууллагын дарга батлан хэлтсийн дарга нар 11 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан гүйцэтгэлд хяналт тавьж 4, 10 дугаар сард явцын ярилцлага хийж 6 дугаар сард хагас жилийн байдлаар үнэлсэн. 19 сумын 21 Газрын даамлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Газрын дарга, тухайн сумын ЗДТГ-ын дарга нараар батлуулан хэрэгжилтэд хяналт тавьж тайланг хагас бүтэн жилээр авч дүгнэн ажиллаж байна.

Долоо. ТЖАТ-д хууль бус томилгоо хийгдсэн эсэх, сул орон тоог олон нийтэд мэдээллэх, захиалга хүргүүлэх, хүний нөөцийн томилгоотой холбоотой шийдвэрийн ил тод нээлттэй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааны талаар.

ГХБХБГ-ын 5 сумын Газрын даамлын сул орон тооны захиалгыг ТАСЗ-д хүргүүлж тусгай шалгалт өгч тэнцсэн 1 иргэнийг Бат-Өлзий сумын газрын даамлаар томилон ажиллууллаа. Үлдсэн 4 сумын сул орон тоог нөхөх төрийн үйлчилгээг иргэдэд тасралтгүй хүргэх зорилгоор 4 мэргэжилтэн албан үүргийг түр орлон гүйцэтгэж журмын дагуу албан тушаалын цалингийн 40 хувийг олгон ажиллуулж байна. ТАЗ-ийн 2023 оны 368 дугаар тогтоолоор албан тушаалын тодорхойлолтод

загдсан мэргэжлийн чиглэлийг нэмж оруулсан боловч мэргэжлийн хүний нөөц хомсдолтой байгаа тул цаашид 4 сумын Газрын даамлын ажлыг нөхөх шаардлага гарч байна.

ТАЙЛАН БИЧСЭН:
ЗАХИРГАА, ХУУЛИЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Г.ДУЛАМДОРЖ